



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.006>

The Science of National Defense, Its Basic Objective Laws (Theoretical development)

Shijee Palamdorj

Sc.D., Professor, Leading researcher, Center for military art, Defense Research Institute of Mongolia

E-mail address: Palamdorjsh1948@gmail.com, ORCID: [0009-0008-6114-1698](https://orcid.org/0009-0008-6114-1698)

Received: 03 June 2026

Revised: 15 June 2026

Accepted: 28 June 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Based on the clarification of national defense science, its content, features, and role in serving society, this article expresses the author's opinion and explanation aimed at discovering the social objective laws of defense science, auxiliary laws and regularities.

Keywords: national defense science; characteristics of defense science; social role of defense science; objective social law of defense science; auxiliary social law of defense science; social regularity of defense science.

Батлан хамгаалах шинжлэх ухаан, түүний үндсэн объектив хууль (Онолын боловсруулалт)

Шижээ Паламдорж

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн Цэргийн урлаг судлалын төвийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор,
Palamdorjsh1948@gmail.com, ORCID: [0009-0008-6114-1698](https://orcid.org/0009-0008-6114-1698)

ХУРААНГУЙ

Үндэсний батлан хамгаалахын шинжлэх ухаан, түүний утга агуулга, шинж, нийгэмд үйлчлэх үүргийг тодруулсны үндсэн дээр батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн объектив хууль, үйлчилж буй туслах хууль, зүй тогтлыг нээн илрүүлэхэд чиглэсэн зохиогчийн үзэл бодол, үндэслэл тайлбарыг энэхүү өгүүлээр илэрхийлсэн болно.

Түлхүүр үг: үндэсний батлан хамгаалахын шинжлэх ухаан; батлан хамгаалах шинжлэх ухааны шинж; батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн үүрэг; батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн объектив хууль; батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн туслах хууль; батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн зүй тогтол.

Оршил

“Үндэсний батлан хамгаалахын шинжлэх ухаан”-ыг бид “цэргийн шинжлэх ухаан”-тай адилтган үзсээр ирсэн (Ш.Паламдорж 2007). бөгөөд түүнийг зэвсэгт мөргөлдөөний объектив хууль* болон цэргийн байгуулалт, хөгжлийн зарчимд суурилуулан тайлбарласаар ирсэн юм. Эдгээр объектив хууль нь дайны мөн чанар, нийгэм-улс төрийн шинж чанар, динамиктай холбоотой байлаа.

Тэгвэл өнөөдөр бидний хувьд “өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй” (“Монгол Улсын Үндсэн Хууль” 1992) бодлого, стратегитэй болсон нь Үндэсний батлан хамгаалахын шинжлэх ухааныг (Ш.Паламдорж 2007, т.64-66) хөгжүүлэх үндэс болсон байна. Батлан хамгаалах шинжлэх ухаан нь цэргийн шинжлэх ухааныг өөртөө багтаасан шинжлэх ухаан болохыг хүлээн зөвшөөрөх боллоо (Ш.Паламдорж 2024, т.69). Тэгэхээр цэргийн шинжлэх ухааны объектив хуулиас өргөн хүрээтэй нийгмийн объектив хууль үйлчилж байгааг нээн тогтоох шаардлага, хэрэгцээтэй тулгарсан байна. Энэ батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн объектив хууль үйлчилж байгааг нээн тогтоох нь бидний судалгааны ажлын үндсэн зорилго болж байна.

Батлан хамгаалах шинжлэх ухааны “эцэг” улс төрийн болон улс төр судлалын шинжлэх ухаан сүүлийн он жилүүдэд зүй тогтлынхоо дагуу хөгжих үндэс манайд тавигдсантай энэ нь холбоотой юм. Нийгмийн шинжлэх ухаан түүн дотроо улс төрийн шинжлэх ухаан нэн эрт үеэс судлагдахуун болж, Аристотель (НОТ-оос өмнөх 384-322 он) (Аристотель 2019, 2018), Платон (НОТ-оос өмнөх 428/427–348/347 он) (Платон. 1972) нар анхаарлаа хандуулж ирсэн хэдий ч Монгол мэтийн коммунизмын дараах улсуудад саяхнаас бие даасан шинэчлэгдсэн судлагдахуун болж байна. Энэ харьцангуй “шинэ” шинжлэх ухаан манайхтай төстэй улсуудад шинжлэх ухааны судлагдахуун болох асуудал нь тэдэнд нийгэм, төрийн сонирхол, хэрэгцээ үүсэж бий болсонтой холбоотой юм. Тодруулж хэлбэл, ардчилсан хувьсгалаас өмнөх манай нийгэмд олон ургалч үзэл, олон намын тогтолцоо, нийгэм, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, хүний эрх, эрх чөлөөний асуудал нэг их чухал байгаагүй, Карл Маркс, Фридрих Энгельс нарын үндэслэсэн марксизм-ленинизмийн гурван бүрэлдэхүүн хэсгийн нэг “шинжлэх ухааны коммунизмын онол” (Карл Маркс, Энгельс 1848; Карл Маркс) гэсэн судлагдахуунаар судлагдаж, шийдвэрлэх ач холбогдол өгч байсан юм.

1992 оноос “Улс төрийн шинжлэх ухааны үндэс” гэсэн шинэ агуулга бүхий хичээл манайд заагдаж эхэлсэн бөгөөд улмаар 1996 онд “Улс төрийн шинжлэх ухаан” гэсэн сурах бичиг хэвлэгдэн гарчээ (А.Цанжид 1996).

Энэ бүхнийг харгалзан үзээд бид *судалгааныхаа объектоор – батлан хамгаалах шинжлэх ухааныг, судлах зүйлээр үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны шинж, үүрэг, түүнд үйлчилж буй хууль, зүй тогтлыг* сонгон авч байна.

Бидний *судалгааны аргазүй нь* объект, үзэгдлийг цогцоор нь судлахад ашигладаг сэтгэлгээ, өгөгдлийг нэгтгэн дүгнэх, далд хэв маягийг тодорхойлох, таамаглал дэвшүүлэх, онолын үндэс болох нийгмийн бодит хууль, зүй тогтлыг илрүүлэхэд чиглэлээ. Онолын задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх үндсэн арга, бодлын тодорхой баримтаас ерөнхий дүгнэлт рүү шилжих хөдөлгөөн индукцийн болон

ерөнхийгөөс тодорхой хүртэлх логик дүгнэлт дедукцийн арга болон объектын үндсэн, чухал шинж чанарыг тодруулах түүний хоёрдогч шинж чанар эсвэл шинж чанараас оюун санааны хийсвэрлэлтийг үндэс болгов. Шинэ мэдлэг олж авахын тулд цэргийн шинжлэх ухааны хуулбар (загвар)-ыг үндэслэх замаар үндэсний батлан хамгаалах шинжлэх ухаан (объект)-ы шинж, аргыг тогтоон энэхүү шинжлэх ухааны нийгмийн бодит хууль, зүй тогтлыг нээн илрүүлэхэд оршлоо.

Үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны судлахууны талаарх хэлэлцүүлэг явагдсан байдлыг товч дурдахад, үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны үндсэн судлахууны талаар манай эрдэмтэн судлаачид нэлээд судалгаа явуулсаар ирсэн бөгөөд тэдний бүтээл туурвил гол төлөв батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, батлан хамгаалах байгуулалт, батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах эрх зүй, эдийн засаг, батлан хамгаалах стратеги, батлан хамгаалах удирдлага, батлан хамгаалахын төлөвлөлт, нөөцийн удирдлага, батлан хамгаалах боловсрол, батлан хамгаалах хамтын ажиллагаа, батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэл талдаа эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл голлож (Батлан хамгаалах бодлого 2015; Аюулгүй Байдал, Батлан Хамгаалах Судлал: Өнөө Ба Ирээдүй 2019) байна. Харин профессор Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж нарын болон Ж.Энхбаяр, Ч.Баттулга зэрэг хүмүүсийн зэрэг нэг сэдэвт бүтээл ([Ц.Дашзэвэг 2019, 2024, 2026](#); [Ш.Паламдорж нарын. 2017](#); [Ж.Энхбаяр 2010](#); [Ч.Баттулга нарын. 2025](#)) хэвлэгдэн нийтлэгдсэн байна. Хэвлэн нийтлэгдсэн бүтээлүүдийг сургалт, судалгаанд өргөн хэрэглэж буй бөгөөд зохиогч бүр өөр өөрсдийн итгэл үнэмшлээр асуудлаа тайлбарлан, үнэн бодитой болохыг нь баталгаажуулахын төлөө ажиллаж иржээ.

Энэ бүхнээс харахад, батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн бодит хууль, зүй тогтлыг нээн илрүүлэхэд чиглэсэн онолын судалгаа бага явагдаж ирсэн байна. Зохиогч өөрийн өмнөх судалгаа ([Ш.Паламдорж 2024, т.64-127](#)) -нд үндэслэн үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн бодит хууль, зүй тогтлыг нээн илрүүлэхэд чиглэсэн дагнасан, гүнзгийрүүлсэн судалгааг явуулж, энэхүү өгүүллээ нийтлүүлж байна.

Нэг. Батлан хамгаалах шинжлэх ухаан, түүний утга агуулга

Өнөө үед монголын нийгэм, төрийн байгуулал өмнөх нийгмийн үеэс өөр шинж чанартай болж, ардчилсан нийгмийн төлөв шинжийг агуулах болсон явдал нь улс төр судлалыг нийгмийн шинжлэх ухааны нэг үндсэн судлагдахуун болгох хэрэгцээ шаардлагыг бий болгосон байна. Тэр тусмаа, түний салбар ухаан – улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан бий болох нь эхлэл төдий түвшиндөө явагдаж буй мэдлэгийн хүрээ юм. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан гэж байх эсэх тухай асуудлыг итгэл, үнэмшил төрүүлэх хэмжээнд илэрхийлэхийн тулд шинжлэх ухааны тухай бага зэргийн тайлбар хийхээс эхлэх нь зохимжтой хэмээн үзэж байна.

“Шинжлэх ухаан” гэсэн үг нь хэд хэдэн үндсэн ойлголт, утга агуулгатай байдаг.

Нэг дэх утга нь, шинжлэх ухаан гэдэг нь байгаль, нийгэм, сэтгэлгээ, хүрээлэн буй ертөнцийн талаарх шинэ мэдлэгийг хөгжүүлэх, системчлэх зорилготой хүний сэтгэлгээ, оюуны үйл ажиллагаа гэж ойлгогддог. Тодруулбал, байгаль, нийгмийн

юмс, үзэгдлийн шинж төлөв, зүй тогтол, бодит хуулийн үечлэлийн талаар танин мэдэх үйл явц юм. Шинжлэх ухааны мэдлэг хүн, нийгэм, улсад үйлчилгээ үзүүлдэг. Улс орныг батлан хамгаалах мэдлэг нь улс, нийгэм, хүний эн тэргүүний хэрэгцээт зүйл, язгуур ашиг сонирхолд хамаарах асуудлаар бүрэлдэж бий болдог нь шинжлэх ухааны судлагдахуун болохыг нөхцөлдүүлж байгаа юм. Тиймээс түүнд: ажиглалт, туршилт хийх (байгаль болон нийгмийн үзэгдэл, үйл явц, практик амьдралыг ажиглах, турших замаар шинэ мэдээлэл цуглуулах, бодит баримт, өгөгдөл дээр тулгуурлан анхдагч мэдлэгийг бий болгох); шинжилгээ, задлан шинжилгээ хийх (цуглуулсан мэдээлэл, өгөгдлийг задлан шинжилж, харилцан хамаарал, хэв маягийг илрүүлэх. Энэ үйлдэлдээ статистик, математик болон бусад шинжлэх ухааны аргыг ашиглах); харилцан хамаарал, нөлөөллийг тогтоох (олон эх сурвалжийн мэдээллийг нэгтгэж, хамааралтай үзэгдэл, үйл явцын талаар гүнзгийрүүлсэн ойлголтыг бий болгох, олон салбарын мэдлэгийг уялдуулан, системчлэхэд туслах); онол, загвар боловсруулах (олж авсан мэдлэг дээр тулгуурлан тодорхой үзэгдэл, үйл явцыг тайлбарлах онол, загваруудыг бий болгох, тогтсон дүгнэлтүүдийг нэгтгэн дүгнэх); таамаглал дэвшүүлэх (буй болсон мэдлэг дээр тулгуурлан ирээдүйн үйл явдал, улс орныг батлан хамгаалахад тулгарах төлөв байдлыг урьдчилан таамаглах, шинэ мэдлэгийг олж авах чиглэлээр судалгаа, туршилтыг төлөвлөх); шалгах, нотлох (дэвшүүлсэн таамаглал, онолыг практик амьдрал, туршилт, судалгаагаар батлах, шалгах үйл явцыг өрнүүлэх); улс орныг батлан хамгаалах мэдлэгийн түгээх (олж авсан мэдлэгийг бусдад дамжуулах, түгээн дэлгэрүүлэх); улс орныг батлан хамгаалах мэдлэгийг тасралтгүй сайжруулах (мэдлэгийг байнга шинэчилж, сайжруулах нь шинжлэх ухааны салбарын хөгжилд нэн чухал бөгөөд үргэлжлүүлэн судалгаа, шинжилгээг явуулж байхыг нөхцөлдүүлнэ).

Хоёр дахь утга нь шинжлэх ухаан нь энэхүү үйл ажиллагааны үр дүн буюу олж авсан шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо (систем) гэж үздэг. Энэ нь судалгаа, шинжилгээ, туршилт, ажиглалт зэрэг шинжлэх ухааны аргуудаар бий болгосон улс орныг батлан хамгаалах мэдлэгийн ойлголт, онол, зарчим, хууль, өгөгдөл, мэдээллүүдийн цогц нэгдэл юм. Энэ системийн гол элементэд: ойлголт, ухагдахуун (категори) (шинжлэх ухааны салбар бүрийн тухайлбал, улс орныг батлан хамгаалах мэдлэгийн тодорхойлолт, ангилал, шинж чанар, харилцан хамаарал зэргээр тодорхойлогддог үндсэн ухагдахуун); онол (улс орныг батлан хамгаалах тодорхой үзэгдэл, үйл явцыг тайлбарлах, урьдчилан таамаглах, хуулийн үндэслэлийг тогтоох системчилсэн ойлголт); зарчим, хууль (байгалийн болон нийгмийн үзэгдэл, тухайлбал, улс орныг батлан хамгаалах үйл явцын хоорондын харилцаа, харилцан хамаарлыг илэрхийлсэн ерөнхийлсөн, туршилтаар батлагдсан дүрэм, хэм хэмжээ); арга (судалгаа, шинжилгээ, туршилт, ажиглалт, математик шинжилгээ зэрэг шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох, батлах аргачлал); өгөгдөл, мэдээлэл (туршилт, ажиглалтын үр дүнд хуримтлуулсан тоон болон чанарын өгөгдөл, тэдгээрийг задлан шинжилсэн мэдээлэл); шинжлэх ухааны баримтууд (бодитой нотлогдсон, туршилт, ажиглалтаар батлагдсан үнэн мэдээлэл, үзэгдэл, үйл явц);

Гурав дахь утга нь, шинжлэх ухааныг хүний нийгмийн ухамсрын нэг хэлбэр гэж ойлгодог. Нийгмийн ухамсар нь хүмүүс нийгмийн бодит байдал (улс орныг батлан хамгаалах асуудал)-ыг ойлгох, хүлээн авах, түүнтэй харилцах хандлага,

зан үйлээр илэрдэг олон янзын хэлбэртэй бөгөөд үүнд шинжлэх ухааны ухамсрын хэлбэрээс гадна дараах хэлбэр байдаг. Эдгээр хэлбэрт: нийгмийн хэвшмэл ухамсар (нийгмийн бүлэг, хамт олонд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн, түгээмэл үнэлэмж, хэм хэмжээ, итгэл үнэмшил); нийгмийн ёс суртахууны ухамсар (ёс зүйн хэм хэмжээ, үнэлэмжүүдийн дагуу зөв бурууг ялгаж салгах чадвар, хүнлэг сэтгэлгээний илэрхийлэл); нийгмийн улс төрийн ухамсар (улс төрийн тогтолцоо, эрх мэдэл, засаглалын талаарх ойлголт, хандлага, үнэлэмжүүдийг илэрхийлэл); нийгмийн эдийн засгийн ухамсар (эдийн засгийн харилцаа, баялгийн хуваарилалт, хөдөлмөрийн үнэлэмж, амьдралын түвшингийн талаарх ойлголт, хандлага); нийгмийн шашин, соёлын ухамсар (шашин шүтлэг, соёлын үнэт зүйлс, ёс заншил, уламжлалыг ойлгож хүлээн авах байдал); нийгмийн экологийн ухамсар (байгаль орчныг хамгаалах, байгальтай зөв зохистой харьцах, экологийн тэнцвэрийг хадгалах хандлага, ойлголт);

Сүүлчийн утга нь шинжлэх ухааны байгууллагууд ба шинжлэх ухааны нийгэмлэгийн гишүүдийн хоорондын харилцааны тогтолцоог илэрхийлдэг, Үүнээс гадна шинжлэх ухааны мэдээллийн систем, шинжлэх ухааны хэм хэмжээ, үнэт зүйлсийн тогтолцоог агуулдаг.

Эдгээрийн хураангуйлан, тодруулан илэрхийлбэл, шинжлэх ухаан нь: **нэгд**, байгаль, нийгэм, сэтгэлгээний объектив хуулиудын мэдлэгийн тогтолцоо; **хоёрт**, мэдлэгийн дэд тогтолцоо (систем), сургаал (жишээлбэл, нийгмийн шинжлэх ухаан – батлан хамгаалах ухаан); **гуравт**, мэдлэг олж авах хүний үйл ажиллагааны цар хүрээ (жишээлбэл, улс орныг батлан хамгаалах асуудлаар мэдлэг олох үйл ажиллагаа); **дөрөвт**, мэдлэг олж авах хэрэгсэл (жишээлбэл, улс орныг батлан хамгаалах асуудлаар мэдлэг олж авахад туслах онол, номлол, сургаал); **тавд**, нийгмийн институци (байгууллагуудын тогтолцоо) юм.

Хоёр. Батлан хамгаалах шинжлэх ухааны шинж, нийгмийн үүрэг

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан бол улс, нийгэмдээ үйлчилдэг шинжлэх ухаан юм. Шинжлэх ухаан бол байгаль, нийгэм, сэтгэлгээний хөгжлийн хуулийн талаарх мэдлэгийн систем, түүнчлэн ийм мэдлэгийг олж авах, үндэслэлтэй болгох, системчлэх үйл ажиллагаа юм. Шинжлэх ухаан нь байгаль, нийгмийн үзэгдэл (улс орныг батлан хамгаалах)-ийг болон хүний оюун ухааныг тайлбарлаж, урьдчилан таамаглах эмпирик өгөгдөл, логик дүгнэлт, туршилтын аргууд дээр суурилдаг.

Энэ бүхнийг нэгтгэн үзвэл, судлаачдын хувьд бол шинжлэх ухаан нь шинжлэх ухааны мэдлэгийг олж авах гол зорилго бүхий тэдний шинжлэх ухааны үйл ажиллагаа юм. Түүний үүрэг нь бодит байдлын талаарх онолын мэдлэгийг системчлэх, хөгжүүлэх явдал юм. Нарийн утгаараа энэ “шинжлэх ухаан” гэсэн нэр томьёо нь судалгааны тодорхой салбаруудын шинжлэх ухааны мэдлэг тодорхойлоход хэрэглэгддэг.

Үүнээс харахад, батлан хамгаалах судлал нь улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан мөн болохыг илэрхийлж байна. Тэгэхээр энэ шинжлэх ухааны шинжлэх ухаанд **эзлэх байр, суурийг тодруулах** хэрэгтэй болж байна.

Үндэсний батлан хамгаалах шинжлэх ухаан нь нийгмийн шинжлэх ухаанд хамаарах ухаан юм. Нийгмийн шинжлэх ухаан нь: социологи, эдийн засаг, улс

төрийн шинжлэх ухаан (улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан), сэтгэл судлалыг өөртөө багтаадаг. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь нийгмийн шинжлэх ухаанд багтах боловч дээр дурдсан шинжлэх ухаануудын дунд, салбар шинжлэх ухаануудын дундын, салбар дамнасан шинжлэх болж байна.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь нэгдсэн шинжлэх ухаанд хамаарагдаж байна. Энэ нь өргөн хүрээний сэдвүүдийг хамарч, янз бүрийн салбаруудын аргуудыг нэгтгэж байгаагаар илэрч, нэгдсэн шинжлэх ухааны шинжийг өөртөө агуулдаг шинжлэх ухаан болж байна.

Үндэсний батлан хамгаалахын үндсэн зорилго нь улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндсэн хуулийн ардчиллыг бүх дотоод болон гадаад аюул заналхийллээс хамгаалах үндэслэлийг тайлбарлах явдал юм. Энэ нь үндэсний тэсвэр хатуужил, иргэдийн сайн сайхан байдлыг хамгаалахын тулд “нийгэм бүхэлдээ” гэсэн хандлагад тулгуурладаг.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан (наука национальной обороны) нь улс орныг гадаад, дотоод аюул, занал, түүнээс хамгаалах арга, хэрэгслийг судалдаг бие даасан шинжлэх ухааны салбар чиглэл юм. Үүнд улс орныг батлан хамгаалах төрийн бодлого, удирдлага, стратеги төлөвлөлт, техник технологийн хөгжил, батлан хамгаалах аж үйлдвэр, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгаа, цэргийн шинжлэх ухаан (цэргийн байгуулалт, цэргийн урлаг, цэргийн бэлтгэл сургуулилт, цэргийн номлол, тактик, зэвсэг, цэргийн тусгай техник, материал, техникийн хангалт) зэрэг багтдаг.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны гол зорилго нь улс орны аюулгүй байдал, бүрэн эрхт байдлыг хангах мэдлэгийг бүтээх явдал юм.

Хэрэв улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааныг мэдлэгийн субъект ба объектын харилцан үйлчлэлийн үүднээс авч үзвэл дараах элементүүдийг агуулж байна.

- объект (субъект)-ын хувьд – улс орныг батлан хамгаалах гэсэн тодорхой шинжлэх ухаан юуг (улс орныг гадны аюул, түрэмгийллээс хамгаалахыг) судалдаг, энэ шинжлэх ухааны мэдлэг ямар зорилготой (аюулгүй байдлыг хангах гадаад, дотоод нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож улс орныг хамгаалах онолын үндэс, удирдамжийг боловсруулах)-г харуулдаг;
- субъектийн хувьд – улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны байгууллага, байгууллагын тодорхой судлаач, шинжлэх ухааны ажилтан, мэргэжилтэн;
- субъектүүдийн шинжлэх ухааны үйл ажиллагаа нь объектив үнэнийг ухаарах, бодит байдлын хууль, зүй тогтлыг нээхэд тодорхой техник, үйл ажиллагаа, аргыг ашигладаг.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны зорилго бол объектив ба субъектив ертөнцийн талаарх мэдлэгийг олж авах, объектив үнэнийг ойлгох явдал юм.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны зорилтууд нь:

- баримтыг цуглуулах, дүрслэх, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, тайлбарлах;
- байгаль, нийгэм, сэтгэлгээ, танин мэдэхүйн хөдөлгөөний хуулиудыг илрүүлэх, нээх;

- Батлан хамгаалах шинэлэг асуудлыг танин мэдэх;
- олж авсан мэдлэгийг системчлэх;
- үзэгдэл, үйл явцын мөн чанарыг тайлбарлах;
- үйл явдал, үзэгдэл, үйл явцыг урьдчилан таамаглах;
- олж авсан мэдлэгээ практикт ашиглах чиглэл, хэлбэрийг тогтоох;
- Батлан хамгаалах асуудлаар шинэ мэдлэг бүтээхэд оршино.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны шинжүүд нь:

Бодит (объектив) шинжтэй. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны судалгааны сэдэв нь судлаачийн үнэлэмж, хувийн болон бүлгийн ашиг сонирхлоос хамаардаггүй бодит шинж (объектив) байдалтай байна. Объектив байдлыг шинжлэх ухааны судалгаанд хамгийн нийлэмжит шинж гэж үздэг. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны бодит объектив шинж нь: улсын аюулгүй байдалд учрах цэрэг, стратегийн байдлаар; цэргийн хүчний чадвар (Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийн чанар, тоо хэмжээ, стратегийн болон тактикийн чадварууд)-аар; техник, технологийн хөгжил (шинэ зэвсэг, техник хэрэгсэл, технологийн инновациудыг нэвтрүүлэх, ашиглах чадвар)-өөр; мэдээллийн аюулгүй байдал (кибер аюулгүй байдлыг хангах, мэдээллийн дайн болон хакерын халдлагаас сэргийлэх арга хэмжээнүүд)-аар; стратегийн бодлого, төлөвлөлт (батлан хамгаалах стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадвар)-өөр; геополитик (улс орны газарзүйн байршил, хөрш орнуудтай харилцах харилцаа, олон улсын байдал)-оор; эдийн засгийн хүчин чадал (батлан хамгаалахын зардал, санхүүгийн боломжууд, эдийн засгийн тогтвортой байдал)-аар; мөн нийгмийн хүчин зүйлс (иргэдийн эх оронч үзэл, батлан хамгаалахын ач холбогдлыг ойлгох байдал, нийгмийн дэмжлэг)-ээр илэрдэг. Эдгээр элементүүд нь улс орныг батлан хамгаалахын шинжлэх ухааныг бодитоор үнэлэх, хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Баталгаат, нотолгоот шинжтэй. Энэ нь нэг дүгнэлтийг өөр өөр судлаачид давтан хүлээн авахад үндэслэдэг. Улс орныг батлан хамгаалахын шинжлэх ухаан нь баталгаат, нотолгоот шинж нь: судалгаа, шинжилгээ (батлан хамгаалахын салбарын судалгаа, шинжилгээний ажлуудыг шинжлэх ухааны аргачлалаар хийж, үр дүнгүүдийг нотолгоотойгоор гарган авдаг. Судалгааны ажлууд нь онолын үндэслэл, туршилт, практикийн үр дүнгүүдэд тулгуурладаг)-гээр; туршилт, сорилтууд (шинэ зэвсэг, техник хэрэгсэл, технологиудыг хөгжүүлэхэд туршилт, сорилтуудыг хийж, тэдгээрийн найдвартай байдал, үр дүнгүүдийг баталгаажуулдаг. Туршилтууд нь бодит нөхцөлд хийгдэж, тодорхой хэмжилтүүд, үзүүлэлтүүдээр нотлогддог)-аар; мэдээллийн систем (батлан хамгаалахын мэдээ, мэдээллийн системүүдийг боловсруулж, тэдгээрийн найдвартай байдал, батлан хамгаалалтын түвшинг тодорхойлох туршилтуудыг хийдэг. Энэ нь кибер аюулгүй байдлыг хангах, мэдээллийн халдлагаас сэргийлэхэд чухал үүрэгтэй)-ээр; стратеги, тактикийн үнэлгээ (улс орныг батлан хамгаалахын стратеги, тактикийн төлөвлөлтүүдийг бодит нөхцөлд үнэлж, тэдгээрийн үр дүнг шинжлэх ухааны аргачлалаар шинжилдэг. Энэ нь улс орны аюулгүй байдлыг хангахад чухал юм)-гээр; эдийн засгийн судалгаа (батлан хамгаалахын зардал, санхүүгийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, эдийн засгийн үр ашгийг үнэлдэг. Эдийн засгийн судалгаагаар батлан хамгаалахын бодлого, шийдвэрүүдийн нөлөөллийг

тодорхойлдог)-аар; олон улсын туршлага, жишээ (бусад орнуудын батлан хамгаалахын шинжлэх ухаан, технологийн хөгжил, туршлага, жишээг судалж, өөрийн орны нөхцөлд тохиромжтой арга замыг хэрэгжүүлэхэд ашигладаг) зэргээр илэрдэг. Эдгээр нь батлан хамгаалахын шинжлэх ухааны баталгаат, нотолгоот шинжийг илэрхийлэх гол элементүүд юм.

Шалгах (баталгаажуулах, турших) боломжит шинжтэй. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны баримт нь түүнийг батлах эсвэл үгүйсгэх бусад судалгаагаар, тэдгээрийн үндэслэлээр нотлогдох учиртай. Баталгаажуулах боломжгүй, хамгийн гол нь үндсэндээ шалгаж, туршиж чадахгүй бол шинжлэх ухааны үндэслэлтэй биш болно. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны шалгах (баталгаажуулах, турших) боломжит шинж нь: туршилт, сорилтууд (шинэ зэвсэг, техник хэрэгсэл, технологиудыг бодит нөхцөлд турших, тэдгээрийн гүйцэтгэл, найдвартай байдлыг үнэлэх. Жишээлбэл, зэвсгийн галын хүч, нарийвчлал, хариу үйлдэл үзүүлэх хурд зэрэг үзүүлэлтүүдийг сорих)-аар; симуляци, загварчлал (байлдааны нөхцөл байдал, стратеги, тактикийн үйл ажиллагааг симуляци, загварчлалаар шалгах. Энэ нь компьютерын загварчлал, симуляци программ ашиглан олон хувилбаруудыг турших боломж олгодог)-аар; бодит байдалд турших (цэргийн сургуулилалт, тактикийн дасгал сургуулилалт хийж, зэвсэгт хүчний бэлтгэл, төлөвлөгөөний хэрэгжилтийг бодит нөхцөлд шалгах. Энэ нь цэргийн ангиудын хамтарсан сургуулилалт, олон улсын хамтарсан дадлага, сургуулилалтын хэлбэрээр илэрдэг)-аар; мэдээллийн дүн шинжилгээ (тагнуулын мэдээ, мэдээллийн үндсэн дээр батлан хамгаалах арга хэмжээг үнэлж, дүн шинжилгээ хийх. Энэ нь цэргийн үйл ажиллагааны үр дүнгүүдийг бодитоор үнэлэхэд чухал үүрэгтэй)-гээр; кибер аюулгүй байдлын шалгалт (кибер аюулгүй байдлын системүүдийг халдлага, нэвтрэлтийн эсрэг турших, найдвартай байдлыг шалгах. Энэ нь кибер дайралтаас сэргийлэхэд чухал үүрэгтэй)-аар; стратеги, тактикийн үнэлгээ (байлдааны стратеги, тактик, үйл ажиллагааны төлөвлөгөө, бодлогыг онолын болон практикийн туршилтаар үнэлж, үр дүнг шинжлэх)-гээр илэрдэг. Энэ нь дайн, байлдааны нөхцөлд стратеги тактикийн зөвшөөрөгдөх, үр дүнг баталгаажуулдаг. Эдгээр шалгах боломжит шинжүүд нь батлан хамгаалахын шинжлэх ухааны бодит байдлыг баталгаажуулах, турших, үнэлэхэд чухал үүрэгтэй.

Тогтолцоот (системт) шинжтэй. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны онол, практик нь хатуу бүтэцтэй, шалтгаан-үр дагавартай байна. Улс орны батлан хамгаалах нь шинжлэх ухааны тогтолцоот (системт) шинж нь: төлөвлөлт ба зохион байгуулалтаар (батлан хамгаалахын үйл ажиллагаа нь стратегийн түвшинд урт хугацааны төлөвлөлт, дунд болон богино хугацааны зохион байгуулалтыг шаарддаг. Энэхүү төлөвлөлт, зохион байгуулалт нь шинжлэх ухааны арга, техник дээр суурилдаг)-аар; технологи ба инноваци (батлан хамгаалахын салбарт ашигладаг зэвсэг, тоног төхөөрөмж, программ хангамжууд нь хамгийн орчин үеийн шинжлэх ухаан, технологид суурилдаг. Жишээлбэл, хиймэл дагуулын технологи, дронуд, кибер аюулгүй байдал зэрэг нь өндөр түвшний шинжлэх ухааны мэдлэгийг шаарддаг)-аар; мэдээллийн менежмент ба анализ (тагнуулын мэдээлэл цуглуулах, боловсруулах, анализ хийх нь шинжлэх ухааны арга техник, загварчлал, статистик анализ дээр суурилдаг. Үүнийг үндэслэн аюулгүй байдлын шийдвэр гаргадаг)-аар; боловсон хүчний бэлтгэл (батлан хамгаалахын мэргэжилтнүүдийг сургах, бэлтгэх

явц нь шинжлэх ухааны үндэстэй хөтөлбөр, сургалтын аргачлал дээр суурилдаг)-ээр; стратегийн судалгаа ба хөгжүүлэлт (батлан хамгаалахын стратеги, тактик боловсруулах, хөгжүүлэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлт дээр тулгуурладаг)-ээр; логистик ба хангалт (цэргийн нэгжүүдийг хангах, тээвэрлэх, нөөцлөх, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаа нь системт шинжлэх ухааны арга техникээр зохион байгуулагддаг)-аар илэрдэг. Эдгээр хүчин зүйлсээс харахад батлан хамгаалах нь зөвхөн цэргийн хүчээр биш, харин шинжлэх ухааны арга, технологи, төлөвлөлт, зохион байгуулалт, судалгаа хөгжүүлэлт зэрэг олон талт системт шинжлэх ухааны тогтолцоотойгоор хэрэгждэг байна.

Логикийн шинжлэлт. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан баримтууд дээр тулгуурлан дүгнэлт гаргах, эдгээр баримтуудын хоорондын уялдаа холбоог илрүүлэхэд оршдог. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан логик шинж нь: онолын үндэслэл (батлан хамгаалах стратеги, тактик, арга хэмжээг боловсруулахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй онолыг ашигладаг. Энэ нь цэргийн үйл ажиллагааг логик дэс дараалалтай, үндэслэлтэй төлөвлөх боломжийг олгодог)-ээр; мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт (батлан хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах үйл явц. Энэ нь алдаа гаргах эрсдэлийг бууруулж, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд тусалдаг)-аар; шинжлэх ухааны аргачлал (батлан хамгаалах асуудлуудыг шийдвэрлэхдээ судалгаа, шинжилгээний шинжлэх ухааны аргачлалыг ашиглах. Энэ нь туршилт, сорил, үнэлгээ, дүгнэлт зэрэг логик үйл явцуудаар баталгааждаг)-аар; стратеги, тактикийн үнэлгээ (байлдааны стратеги, тактикийн төлөвлөгөөг логик үндэслэлээр боловсруулж, байлдааны нөхцөлд хэрхэн хэрэгжихийг үнэлэх. Энэ нь стратеги, тактикуудын үр дүнтэй байдлыг логик аргаар шалгах боломжийг олгодог)-ээр; үр дагаврын шинжилгээ (батлан хамгаалах бодлого, арга хэмжээний үр дагаврыг урьдчилан таамаглах, эрсдэлийг үнэлэх замаар логик үнэлгээ хийх. Энэ нь бодлого, шийдвэрүүдийн урт хугацааны нөлөөллийг ойлгоход тусалдаг)-ээр; системийн хандлага (батлан хамгаалах үйл ажиллагааг системийн хандлагаар авч үзэж, бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, үйл ажиллагааны уялдаа холбоог логик үндэслэлээр шинжилнэ. Энэ нь цэргийн хүчний үр дүнтэй байдлыг хангах боломжийг нэмэгдүүлдэг)-аар илэрдэг. Эдгээр нь улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны логик шинжийг илэрхийлж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тусгай аргуудтай. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь оюун санааны үйл ажиллагааны бусад хэлбэр (ёс суртахуун, шашин шүтлэг, урлаг, боловсрол) -ээс ялгах өөрийн гэсэн судалгааны аргыг ашиглана. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны тусгай аргуудад: батлан хамгаалах стратеги ба тактикийн шинжилгээ (дайснаас ямар аюул учруулж болох, түүнээс ямар арга замаар хамгаалах, дипломат болон цэргийн аргыг хэрхэн ашиглах, хэрхэн хориглон хамгаалах, довтлох, давших зэрэг үйл ажиллагааг онолын болон практикийн аргуудаар шинжлэх); тагнуул ба мэдээлэл цуглуулах (дайсны хүч, зорилго, стратеги, байршлыг олж мэдэх зорилгоор тагнуулын үйл ажиллагаа явуулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх); зэвсэг, техник хэрэгслийн туршилт (шинэ зэвсэг, техник хэрэгслийг бодит нөхцөлд турших, тэдгээрийн гүйцэтгэл,

найдвартай байдлыг шалгах); симуляци ба үйлдлийн загварчлал (байлдааны нөхцөл байдал, стратеги, тактикийн үйл ажиллагааг компьютерын симуляци, үйлдлийн загварчлал ашиглан турших, үнэлэх); кибер аюулгүй байдлын аргууд (кибер дайралтаас хамгаалах, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх); логистикийн дүн шинжилгээ ба төлөвлөлт (цэргийн хүчний нөөцийг зөв хуваарилах, тээвэрлэлтийн логистикийг зохицуулах, хангалтын системийг оновчтой болгох арга хэмжээ); бодлого боловсруулалт ба стратегийн төлөвлөлтийн арга (батлан хамгаалахын бодлого, стратеги, урт хугацааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ); эдийн засгийн үнэлгээ ба төсөвлөлтийн арга (батлан хамгаалахын зардал, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, төсөвлөлт хийх, эдийн засгийн нөлөөллийг үнэлэх арга хэмжээ); сургалт ба дадлага (цэргийн сургалт, бэлтгэлийг зохион байгуулах, бодит байлдааны нөхцөлд туршиж, дадлагажуулах) зэрэг арга багтана. Эдгээр тусгай аргууд нь улс орныг батлан хамгаалахын шинжлэх ухааныг хөгжүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны ерөнхий чиг үүрэг:

Танин мэдэхүйн чиг үүрэг – улс орныг батлан хамгаалахын учир холбогдол, хөгжлийн зүй тогтол, үйлчилж буй бодит хуулийн талаарх мэдлэг, тайлбар хийх явдал юм. Энэ нь: мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх (дайсны хүч, зорилго, стратегийг ойлгох, улмаар үр дүнтэй арга хэмжээ авахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх. Энэ нь тагнуулын ажиллагаа, мэдээллийн дүн шинжилгээ зэргээр илэрхийлэгддэг); үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжилт (батлан хамгаалах арга хэмжээ, стратегийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх. Үүнд цэргийн тактик, стратегийн төлөвлөгөө боловсруулах, логистик үйл ажиллагааг зохицуулах зэрэг орно); туршилт, сорилт, үнэлгээ (шинэ зэвсэг, техник хэрэгслийг турших, тэдгээрийн үр дүнг үнэлэх. Мөн байлдааны сургуулилалт, симуляци ашиглан стратеги, тактикийн үр дүнг шалгах); хөгжүүлэлт ба инноваци хийх (батлан хамгаалах технологийг хөгжүүлэх, шинэ зэвсэг, техник хэрэгслийг нэвтрүүлэх, инноваци хийх. Шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтийн ажлууд энд багтана); бодлого боловсруулах (улс орны батлан хамгаалахын бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулах, хэрэгжүүлэх. Үүнд аюулгүй байдлын стратеги, хамгаалалтын бодлого зэрэг орно); олон улсын нөхцөл байдлыг ойлгох (гадаад улс орнуудын стратеги, бодлого, үйл ажиллагааг судлах, дүн шинжилгээ хийх. Олон улсын харилцааны хүрээнд улс орны байр суурийг тодорхойлох); эдийн засгийн нөлөөллийг мэдэх (батлан хамгаалах арга хэмжээний эдийн засгийн үр дагаврыг мэдэх, санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглах) зэргээр илэрхийлэгдэнэ. Эдгээр танин мэдэхүйн чиг үүргүүд нь улс орны батлан хамгаалах шинжлэх ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Урьдчилан таамаглах чиг үүрэг – улс орныг батлан хамгаалах асуудлыг шинжлэх ухаанч мэдлэгт үндэслэн ирээдүйг урьдчилан таамаглах явдал юм. Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны урьдчилан таамаглах чиг үүрэг нь: аюул заналыг урьдчилан таамаглах (болзошгүй аюул, эрсдэлийг урьдчилан таамаглаж, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээг төлөвлөх. Үүнд тагнуулын мэдээ, мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх, аюулын түвшинг үнэлэх); цэргийн стратеги, тактикийн үр дүнг таамаглах (болзошгүй байлдааны нөхцөл байдлыг

урьдчилан таамаглаж, стратеги, тактикийн төлөвлөгөөг боловсруулах. Үүний тулд симуляци, загварчлал, туршилт ашиглах); эдийн засгийн нөлөөллийг урьдчилан таамаглах (батлан хамгаалах арга хэмжээний эдийн засгийн үр дагаврыг урьдчилан таамаглаж, санхүүгийн нөөцийн зохистой хуваарилалтыг хийх); технологийн хөгжлийг таамаглах (ирээдүйн технологийн дэвшлийг урьдчилан таамаглаж, зэвсэг, техник хэрэгслийн шинэчлэлт, сайжруулалтыг хийх); олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийг таамаглах (гадаад улс орнуудын бодлого, үйл ажиллагааны өөрчлөлтийг урьдчилан таамаглаж, тэдгээрт зохицсон арга хэмжээг төлөвлөх); цэргийн хүчний хэрэгцээ, шаардлагыг урьдчилан таамаглах (цэргийн хүчний ирээдүйн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан таамаглаж, бэлтгэл сургуулилалт, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хангалтыг төлөвлөх); байгалийн болон хүний оролцоотой гамшгийг урьдчилан таамаглах (байгалийн гамшиг, цар тахал, нийгмийн үймээн самуун зэрэг хүний болон байгалийн гаралтай аюулыг урьдчилан таамаглаж, хариу арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх) зэргээр илэрхийлэгдэнэ. Эдгээр урьдчилан таамаглах чиг үүргүүд нь улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааныг бодитоор хэрэгжүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Нийгмийн шинжлэх ухааны (салбар шинжлэх ухаан мөнхийн хувьд) **чиг үүрэг нь** нийгэмд болж буй үйл явцад нөлөөлж, түүний нээлт нь улс, нийгэм, эдийн засгийн амьдралыг сайжруулахад туслах, үйлчлэх явдал юм. Энэ нь: аюулгүй байдлыг хангах (батлан хамгаалах шинжлэх ухаан нь улс орны аюулгүй байдлыг хангаж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулна. Үүнд кибер аюулгүй байдал, терроризмын эсрэг арга хэмжээ, хил хязгаарын хамгаалалт зэрэг багтана); технологийн хөгжлийг дэмжинэ (батлан хамгаалах салбарт хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, технологийн инновациуд нь иргэний салбарт ашиглагдаж, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна. Жишээлбэл, интернэт, GPS системүүд анх батлан хамгаалахын зориулалтаар хөгжүүлсэн байдаг); эдийн засгийн хөгжлийг дэмжинэ (батлан хамгаалахад зарцуулагдсан хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Үүнд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх зэрэг багтана); боловсрол, сургалтыг дэмжинэ (батлан хамгаалах салбар дахь судалгаа, сургалт нь шинжлэх ухаан, технологийн боловсролыг дэмжиж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд тусална Энэ нь нийт боловсролын түвшинг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна); олон улсын хамтын ажиллагааг дээшлүүлнэ (батлан хамгаалах салбар дахь олон улсын хамтын ажиллагаа нь улс орнуудын харилцан итгэлцлийг нэмэгдүүлж, энх тайвныг дэмжихэд тусална. Мөн хамтын ажиллагааны хүрээнд эдийн засаг, худалдаа, технологийн солилцоо сайжирна); гамшгийн удирдлагыг сайжруулна (батлан хамгаалах шинжлэх ухааны арга, технологиудыг байгалийн гамшиг, онцгой байдлын үед ашиглаж, гамшгийн эрсдэлийг бууруулах, хүн амыг хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ); хууль эрх зүйн орчныг сайжруулна (батлан хамгаалах салбарт гарсан судалгаа, туршилт нь хууль эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн тогтвортой байдлыг хангахад тусална). Эдгээр хүчин зүйлүүд нь батлан хамгаалах шинжлэх ухааны нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг харуулж, улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг илэрхийлнэ.

Үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүрэг – улс орныг батлан хамгаалах шинжлэх

ухаан нь улс, нийгмийн язгуур ашиг сонирхлын дагуу үйлдвэрлэлд шинийг нэвтрүүлэх, илүү хурдан, чанартай болгох технологийг бий болгоход оршино. Энэ нь: шинэ технологи, инноваци хөгжүүлэхэд (батлан хамгаалах салбар дахь судалгаа, шинжилгээ нь шинэ технологи, инноваци хөгжүүлэхэд түлхэц болно. Эдгээр технологи, инновациуд нь иргэний үйлдвэрлэлд нэвтэрч, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна); үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулахад (батлан хамгаалахын хэрэгцээнд зориулагдсан үйлдвэрлэл нь өндөр чанар, найдвартай байдлыг шаарддаг тул үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулж, орчин үеийн тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэхэд тусална); судалгаа, хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтад (батлан хамгаалах салбар дахь судалгаа, хөгжүүлэлтийн ажилд оруулсан хөрөнгө оруулалт нь иргэний үйлдвэрлэлийн салбарын судалгаа, хөгжүүлэлтийг дэмжиж, үйлдвэрлэлийн салбарт шинэчлэлт хийхэд хувь нэмэр оруулна); мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд (батлан хамгаалахын салбар дахь сургалт, боловсрол нь өндөр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд чиглэгдэг. Эдгээр мэргэшсэн боловсон хүчин нь иргэний үйлдвэрлэлийн салбарт шилжиж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ); үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлэхэд (батлан хамгаалах салбар дахь хэрэгцээ шаардлага нь үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлэхэд түлхэц болно. Жишээлбэл, аюулгүй байдлын тоног төхөөрөмж, электрон системүүд, мэдээллийн технологийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх шинэ салбарууд бий болгох); эдийн засгийн өсөлтийг дэмжихэд (батлан хамгаалах салбар дахь үйлдвэрлэл нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх, орлого, татварын орлогыг нэмэгдүүлэхэд тусална); олон улсын хамтын ажиллагаагаар (батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, хамтарсан төслүүд нь технологи, мэдлэг, туршлага солилцох боломжийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ) зэргээр илэрхийлэгдэнэ. Эдгээр хүчин зүйлс нь батлан хамгаалах шинжлэх ухаан нь үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг харуулна.

Ертөнцийг үзэх үзэл төлөвшүүлэх үүрэгтэй – улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь оюун санааны салбарын элемент болох хувь хүн, нийгмийн ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэхэд нөлөөлнө. Энэ нь: эх оронч үзлийг төлөвшүүлэх (батлан хамгаалах шинжлэх ухаан нь хүмүүсийн эх оронч үзэл, хайрлах сэтгэлийг төрүүлэх, улс орныхоо төлөө зүтгэх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт явуулдаг); аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх (хүмүүсийг улс орныхоо аюулгүй байдлын талаар мэдлэгтэй болгож, болзошгүй аюул занал, эрсдэлийг ойлгож, түүнд бэлэн байх хандлагыг төлөвшүүлдэг); нийгмийн хариуцлагыг ухамсарлуулах (батлан хамгаалахын шинжлэх ухаан нь хүмүүсийг нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлах, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах чухлыг ойлгуулдаг); эв нэгдлийг бэхжүүлэх (батлан хамгаалахын салбар дахь үйл ажиллагаа нь хүмүүсийг хамтран ажиллах, нэг зорилгын төлөө нэгдэн зүтгэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд тусалдаг. Энэ нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй); тууштай, сахилга баттай байдалд сургах (цэргийн сургалт, дадлага нь хүмүүсийг сахилга баттай, тууштай байх, бэрхшээлтэй нөхцөлд тэвчээртэй хандах чадварт сургадаг. Энэ нь иргэн амьдралдаа хат суух, сөрөн тэсвэрлэх чадвартай болоход чухал үүрэг гүйцэтгэдэг); бодит нөхцөл байдлыг зөв үнэлэх чадвар (батлан хамгаалахын салбар дахь

судалгаа, шинжилгээ нь хүмүүсийг бодит нөхцөл байдлыг зөв үнэлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийх чадварт сургадаг); Олон улсын харилцааг ойлгуулах (батлан хамгаалах шинжлэх ухаан нь олон улсын харилцаа, улс орнуудын хоорондын харилцан хамаарал, энх тайвны ач холбогдлыг ойлгуулахад тусалдаг. Энэ нь хүмүүсийн ертөнцийг үзэх үзэлд эерэг нөлөө үзүүлдэг) зэрэг арга замаар хэрэгжүүлнэ. Эдгээр замууд нь батлан хамгаалах шинжлэх ухаан нь хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл төлөвшүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг харуулна.

Боловсролын чиг үүрэг: Улсын батлан хамгаалах шинжлэх ухаан нь цэргийн боловсролын тогтолцооны үндэс суурь болж, хуримтлуулсан мэдлэг, танин мэдэхүйн аргуудыг цэргийн алба хаагчдад дамжуулна. Үүнийг: сургалт, боловсролын хөтөлбөрүүд (батлан хамгаалах салбар дахь мэргэжилтнүүдийг бэлтгэх, сургах зорилгоор их дээд сургуулиуд, мэргэжлийн сургалт, судалгааны төвүүдтэй хамтран боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх); судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих (батлан хамгаалах шинжлэх ухаан нь их, дээд сургуулиудын судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, дэмжих замаар боловсролын салбарын хөгжилд хувь нэмэр оруулдаг); шинжлэх ухаан, технологийн дэвшлийг сурталчлах (цэргийн технологи, шинжлэх ухааны дэвшлийг сурталчлах, иргэдэд танилцуулах, тэдгээрийг иргэний салбарт нэвтрүүлэх боломжийг судлах); хамтарсан төслүүд хэрэгжүүлэх (их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан төслүүдийг хэрэгжүүлж, оюутнууд, судлаачдад туршлага хуримтлуулах, мэдлэгээ нэмэгдүүлэх боломж олгох); тэтгэлэг, тэтгэлэгт хөтөлбөрүүд хэрэгжүүлэх (батлан хамгаалах салбар дахь өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор оюутнуудад зориулсан тэтгэлэг, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх); сургуулиудын дэд бүтцийг сайжруулах (батлан хамгаалахын салбар дахь хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах); мэргэжлийн дадлага, туршлага олгох (оюутнуудад батлан хамгаалах салбарт дадлага хийх, мэргэжлийн туршлага хуримтлуулах боломжийг олгох); семинар, конференци зохион байгуулах (батлан хамгаалах салбар дахь шинэ технологи, судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор семинар, конференци, сургалт зохион байгуулах) зэргээр хэрэгжүүлнэ. Эдгээр арга замууд нь батлан хамгаалах шинжлэх ухаан нь улс орны боловсролыг дэмжих чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулж байна.

Улс төрийн шинжлэх ухааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан учраас улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь улс төр судлалын нэг хэсэг, нийгмийн шинжлэх ухааны нэг үндсэн судлагдахуун юм. Улс орныг батлан хамгаалах судлал (ухаан) шинжлэх ухааны судлагдахуун буюу судалгааны объект байснаараа уг асуудлын шинжлэх ухаанч байдлыг бүрэн хангаж чадахгүй юм. Тиймээс энэхүү судалгааны объект – судлагдахууныг судлах зүйлүүдэд задалж, мөн чанарыг нь тунгаан тайлбарлах шаардлагатай болох нь ойлгомжтой байна.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухааны үндсэн судлах зүйл нь:

1. Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах үндэс;
2. Улс орныг батлан хамгаалах эрх ашгийн төлөөх мэдээлэл (тагнуул, сөрөг

- тагнуулаар);
3. Улс орныг батлан хамгаалахад нөлөөлөгч гадаад, дотоод аюул, тэдгээрийн мөн чанар, шинж, төлөв, нөлөөлж буй хүчин зүйл, заналын түвшин, эрсдэл;
 4. Улс орныг батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл;
 5. Улс орныг батлан хамгаалах стратеги, түүний төлөвлөлт;
 6. Цэргийн номлол – Зэвсэгт хүчнийг хэрхэн ашиглах үзэл баримтлал;
 7. Батлан хамгаалахад шаардагдах Зэвсэгт хүчин, түүний бүтэц, бүрэлдэхүүн, ЗХ-нийг хөгжүүлэх стратеги, хөтөлбөр;
 8. Батлан хамгаалахын эдийн засгийн үндэс, эдийн засгийн эрсдэл нь улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолд нөлөөлөгч хүчин зүйл;
 9. Батлан хамгаалах аж үйлдвэр;
 10. Иргэний хамгаалалт, гамшгаас хамгаалах асуудал;
 11. Улс орныг батлан хамгаалахад бүх нийтийн оролцоог хангах орон нутгийн хамгаалалт;
 12. Эх орноо хамгаалахад ард иргэд оролцох бэлтгэл, бүх нийтийн дайчилгаа;
 13. Дайны цагт улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хадгалах, хамгаалахад дэмжлэг үзүүлэгч улстай хамтран ажиллах байр суурь, зарчим, чиглэл;
 14. Үндсэн хуульт төрийн байгуулал, түүнийг хууль бусаар бусниулахын эсрэг хийх тэмцэл, түүний хэлбэр, агуулга;
 15. Нийгмийн байгууламжийн зохистой харьцаа, аюулгүй байдлыг хангах үндсэн асуудал;
 16. Шинжлэх ухаан, технологи, уламжлалт технологит учирч болзошгүй занал, эрсдэл, түүнийг арилгах арга зам;
 17. Мэдээллийн аюулгүй байдал ба улс орныг батлан хамгаалах эрх ашиг гэх мэт.

Улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан нь нийгмийн шинжлэх ухааны салбар шинжлэх ухааны мөнийн хувьд сэтгэлгээний үр нөлөөгөөр бодит биеллээ олдог. Эйнштейн “бүх шинжлэх ухаан бол өдөр тутмын сэтгэлгээг сайжруулахаас өөр зүйл биш” гэсэн нь шинжлэх ухаан зөвхөн хүний сэтгэлгээний үр дүнгийн бүтээгдэхүүн болохыг илэрхийлж буй хэрэг юм. Тэгэхээр улс орныг батлан хамгаалах шинжлэх ухаан (наука национальной обороны) нь хүний сэтгэлгээний үр дүнгээр системчлэгсэн мэдлэгийн тогтолцоо болно. Улс орныг батлан хамгаалах ухааныг сэтгэлгээний үр дүн гэж байгаа нь “сэтгэн бодох” гэдгээ жинхэнэ утгаар нь ойлгохоос эхэлнэ.

Сэтгэн бодох нь объектив ертөнцийн объект, үйл явцын мөн чанар, тэдгээрийн үндсэн шинж чанар, хоорондын харилцан хамаарлын талаарх хүний оюун ухаан дахь тусгал болох хувь хүний танин мэдэхүйн үйл явцын нэг хэсэг нь (мэдрэхүй, ойлгохуй, санахуй, төсөөлөхүй г.м.) юм.

Сэтгэлгээ нь танин мэдэхүйн түвшинд шууд хүлээн авах боломжгүй объект, шинж чанар, харилцан хамаарлын талаарх мэдлэгийг олж авах боломжийг хүнд

олгодог. Сэтгэлгээг энгийн (өдөр тутмын) болон шинжлэх ухааны гэж ангилан үздэг.

Энгийн сэтгэлгээ гэдэг нь өдөр тутмын туршлага гэж нэрлэгддэг нийтлэг ойлголт дээр суурилсан, анхдагч логик шинжилгээ ашигладаг сэтгэхүй юм.

Шинжлэх ухааны сэтгэлгээ нь бодит ертөнцийн гүн дэх мөн чанарыг танин мэдэх, нотлох баримт, бодит байдал, тогтолцоот байдлын шалгуурыг хангахад чиглэсэн сэтгэхүй юм.

Сэтгэн бодох үйл явцыг, судлаачид өдөр тутмын сэтгэлгээ нь тийм ч “шинжлэх ухаан ч биш” гэх, харин шинжлэх ухааны сэтгэлгээ нь өдөр тутмын “амьдралаас хөндийрсөн” гэх туйлшрал гаргах нь байдаг. Үнэн чанартаа, энэ хоёр төрлийн сэтгэлгээ нь танин мэдэхүйн ижил механизм дээр суурилдаг. Сэтгэлгээний энэ хоёр төрөл нь адилхан алдаж, онодог, хийсвэрлэлийг адилхан ашигладаг.

Тэгэхээр хийсвэрлэл нь объект, систем, үзэгдлийн чухал шинж чанар, онцлогийг харуулахын зэрэгцээ түүний үндсэн шинж чанарыг онцлон ялгахын тулд чухал бус нарийн ширийн зүйлийг хийсвэрлэх үйл явц юм. Энэ аргыг програмчлал, математик, гүн ухаан, урлаг гэх мэт янз бүрийн салбарт ашигладаг бөгөөд хамгийн чухал талуудад анхаарлаа төвлөрүүлж, нарийн төвөгтэй ойлголтуудыг ойлгох, дүн шинжилгээ хийх ажлыг хялбарчлах зорилгоор ашигладаг.

Дээр өгүүлсэн бүхнийг нэгтгэвээс, улс орныг (үндэсний) батлан хамгаалах шинжлэх ухаан нь үндэсний аюулгүй байдлыг хангах онолын болон хэрэглээний талыг судалдаг салбар дундын мэдлэгийн салбар болох нь тодорхой байна. Батлан хамгаалах судлал Зэвсэгт хүчний стратеги, тактик, технологи, зохион байгуулалт, удирдлага, улс төр, олон улсын харилцаа зэрэг олон сэдвийг хамарч байна. Улс орныг (үндэсний) батлан хамгаалах шинжлэх ухааны оронд, цэргийн чадавх өндөртэй, цэргийн ажиллагааг өөрийн улсын газар нутгаас гадна улс орныхоо ашиг сонирхлыг хамгаалах үүднээс явуулдаг улсуудад цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж ирсэн болохыг дурдах нь зөв байх хэмээн үзэж байна.

Гурав. Батлан хамгаалах шинжлэх ухааны нийгмийн объектив хууль, үйлчилж буй туслах хууль, зүй тогтол

Аливаа шинжлэх ухааны судалгааны объект нь эрдэмтдийн судлахаар сонгосон бодит ертөнц, юмс, үзэгдлийн чиглэл салбар буюу бидний хувьд улс, эх орноо хамгаалах юм. Судлах зүйл нь улс орноо батлан хамгаалах бодлого юм. Улс орноо батлан хамгаалах бодлого нь төрийн бодлогын нэг хэсэг бөгөөд төрийн бодлого нь улс төрийн бодлогын нэг хэсэг байдаг. Энэ үүднээс нь авч үзвэл, орноо хамгаалах бодлого нь улс төрийн бодлоготой холбогддог. Тэгэхээр улс төрийн бодлогын болон төрийн бодлогын онолтой улс орноо батлан хамгаалах бодлогын онол шууд болон дам утгаараа холбоотой байна.

Улс төрийн бодлогын онол (politics, политика) болон олон нийт (төр)-ийн бодлогын онол¹ (public policy, policy, государственная политика или политика)-

¹ Тайлбар: “Олон нийтийн бодлого” (Public Policy, государственная политика) болон “төрийн бодлого” (Politics of the State/State Policy, политика государства) нь ихэвчлэн ижил утгатай хэрэглэгддэг ойлголтууд боловч улс төрийн шинжлэх ухаан болон төрийн захиргаанд өөр өөр онцлох үйл явцтай байдаг. Эдгээрийн онолын мөн чанар, тэдгээрийн ялгаа нь:

“Олон нийтийн бодлого” (Public Policy, государственная политика) нь нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд засгийн газрын байгууллагууд (гүйцэтгэх болон хууль тогтоох)

ын ялгаа нь судалгааны гол цөмд оршдог: эхнийх нь төр, засгийн эрх мэдлийн төлөөх тэмцлийг судалдаг бол сүүлийнх нь төр энэ эрх мэдлийг хэрэгжүүлэх аргыг судалдаг. Бид өөрсдийн энэхүү бүтээлдээ олон нийтийн бодлогын онол гэсэн нэр томъёог бага ашиглаж, төрийн бодлогын онол гэсэн нэр томъёог түлхүү ашиглана.

Улс орноо батлан хамгаалах бодлогын онол нь үндэсний батлан хамгаалахын шинжлэх ухааны объектив хууль, зүй тогтлоос урган гарсан, түүнтэй нягт уялдаа холбоотой байна. Түүнийг үл харгалзах аваас бодлогын онол нь шинжлэх ухааны үндэслэл муутайд тооцогдоно. Үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны объектив хуулийг дараах байдлаар илэрхийлж болох байна.

Үндэсний батлан хамгаалах (үндэсний аюулгүй байдлыг хангах)-ын шинжлэх ухааны объектив хууль нь субъектив (төрийн) хүсэл зоригоос үл хамааран явагддаг үйл явц бөгөөд тэр нь тогтвортой, давтагддаг, улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалахын төлөөх учир шалтгаант харилцаа юм.

Үндэсний батлан хамгаалахын объектив хуулиас гадна төрийн удирдлага, үндэсний аюулгүй байдал, цэргийн хэргийн зарчимд үндэслэн объектив хуульд нийцсэн дараах туслах хууль, зүй тогтол үйлчилж байдаг:

1. Батлан хамгаалах арга хэмжээ нь аюул заналын цар хүрээ, шинж чанартай нийцэх хуульд захирагдана. Энэ нь улс орныг батлан хамгаалах нь гадаад болон дотоод аюул заналын түвшинд нийцэж байх тухай юм. Энэ нь аюул заналын түвшин (цэргийн, эдийн засгийн, мэдээллийн, кибер) өндөр байх тусам батлан хамгаалах тогтолцоо (систем) нь илүү дайчлагдах, цогц байх, зүй тогтолтойг илэрхийлдэг. Жишээ: Газар, тэнгисээс ирэх аюулаас агаараас ирэх аюул нэмэгдэх нь агаараас ирэх аюулаас хамгаалах арга, хэрэгслийг ихэсгэх, эдийн засаг, техник, технологийн механизмыг өөрчлөх шаардлагатай болгодог.

2. Системчилсэн аюулгүй байдлын хууль үйлчилж байдаг. Энэ хууль нь улс орныг батлан хамгаалах нь зөвхөн цэргийн хүч төдийгүй төрийн бүх бүтцийн нэгдсэн ажиллагаа бөгөөд аюулгүй байдлыг зөвхөн цэргийн аргаар хангах боломжгүйгээс эдийн засаг, мэдээлэл, нийгэм, боловсрол, шинжлэх ухаан, соёл гэх зэрэг бүхэл бүтэн тогтолцоо (систем)-г хамарсан байх зүй тогтлоор илэрхийлэгддэг. Энэ зүй тогтол батлан хамгаалах чадвар, эдийн засгийн тогтвортой байдал, мэдээллийн аюулгүй байдлын харилцан хамааралд оршдог зүй тогтолтойг дам илэрхийлдэг.

3. Улс орноо батлан хамгаалах чадвар эдийн засаг, технологийн боломжоос хамаарах хуульд захирагддаг. Улсын эдийн засгийн хүч бол цэргийн хүчний үндэс суурь юм. Хоцрогдсон эдийн засагтай улс зэвсэглэл, технологийн давуу талыг богино хугацаанд бүрдүүлэх боломжгүй юм. Тиймээс улс орныг батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэх, армийг орчин үеийн зэвсгээр хангах нь стратегийн шинжийг агуулж, тогтвортой, найдвартай материал, техникийн бааз шаардагддаг.

хэрэгжүүлдэг тодорхой арга хэмжээ, үйлдэл, шийдвэр, хэрэгслийн систем юм. Мөн чанар нь: Засгийн газрын олон нийтийн эрэлт хэрэгцээнд үзүүлэх хариу үйлдэл юм. Жишээ нь боловсролын бодлого, татварын бодлого, ажилгүйдэлтэй тэмцэх арга хэмжээ. Харин “төрийн бодлого” (Politics of the State/State Policy, политика государства) нь засгийн газрыг удирддаг ерөнхий чиглэл, зарчим, зорилго, ашиг сонирхлыг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм. Мөн чанар нь: Энэ бол улс орны хөгжлийн чиглэлийг тодорхойлдог стратеги, үзэл суртал юм. Жишээ нь: гадаад бодлого, дотоод бодлого, аюулгүй байдал, бүрэн эрхт байдал.

4. Цэргийн ажиллагаа, ар тал (цэрэг ба нийгэм, төр)-ын нэгдмэл байдлын хууль үйлчилж байдаг. Улс орныг хамгаалах нь зөвхөн иргэний нийгмийн, төрийн бодлого түүнийг дэмжсэн тохиолдолд л үр дүнтэй байна. Төрийн тогтвортой байдал, нийгмийн нэгдмэл байдал, хүн амын амьдралын түвшин, үзэл суртлын тогтвортой байдлаас улс орныг хамгаалах нь бүрэн хамааралд оршдог. Түүхийн үнэнийг болон үндсэн үнэт зүйлс – язгуур эрх ашгийг ард иргэд ухамсарласан байх нь улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үндэс суурийг бүрдүүлж өгдөг.

5. Улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ тэргүүлэх ач холбогдолтой болох тухай хууль. Аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх нь түүний үр дагавартай тэмцэхээс илүү үр дүнтэй байна. Орчин үеийн геополитикт аюул заналхийллийг урьдчилан таамаглаж, эрт үе шатанд нь арилгах чадвартай тал нь ялагч болно (дипломат ажиллагаа, тагнуул, кибер аюулгүй байдал).

6. Хууль эрх зүйн хүрээнд тулгуурлах хууль. Улс орныг батлан хамгаалах нь засгийн газрын үйл ажиллагааны хууль ёсны байдлыг хангадаг хууль эрх зүйн хүрээнд (Үндсэн хууль, түүнд нийцүүлсэн бусад хууль тогтоомж) явагдана. Хууль эрх зүйн орчин нь үндэсний аюулгүй байдлын тогтолцоо (систем)-ны үйл ажиллагааг хангана.

Объектив хууль болон түүнд нийцсэн туслах хууль, зүй тогтлын үйлчлэл нь: аюул заналхийлэлд байнга дүн шинжилгээ хийх, нийгмийн эв нэгдлийг хангах, эдийн засгийг бэхжүүлэх, амьдралын бүхий л салбарыг хамарсан цогц арга барилыг шаарддаг байна.

ДҮГНЭЛТ

Объектив хууль бол байгаль, нийгэм дэх юмс, үзэгдэл (үйл явц)-ын хоорондын үндсэн, зайлшгүй, тогтвортой, давтагдах харилцаа (холбоо) юм. Объектив хуулийн тухай ойлголт нь мөн чанарын тухай ойлголттой дүйцэхүйц бөгөөд энэ нь объектын хөгжлийн хамгийн чухал шинж чанар, чиг хандлагыг тодорхойлдог үзэгдлийн хоорондох гүн гүнзгий (дотоод) холбоосын цогцыг илэрхийлдэг. Энэ үүднээс авч үзвэл объектив хууль бол тогтвортой, давтагдах шалтгаан-үр дагаврын харилцаа, харилцан хамаарлыг тусгадаг.

Объектив хууль бол үргэлжийн харилцаа, үзэгдлийн хоорондох холбоо боловч харилцаа бүр хууль болж үйлчилдэггүй; үүнтэй адил хууль бол хандлага юм (гэхдээ зүгээр бүх ямар ч хандлага биш). Тиймээс хуулийг тодорхой төрөл зүйл эсвэл ангиллын бүх үзэгдэл, үйл явцад орших, тодорхой нөхцөлд илэрдэг ерөнхий харилцаа холбоог тусгасан тул түүнийг нийтлэг байдлын нэг хэлбэр гэж ангилах нь зүйтэй.

Үндэсний батлан хамгаалахын объектив хуулиас гадна объектив хуульд нийцсэн дараах туслах хууль, зүй тогтол үйлчилж байна: батлан хамгаалах арга хэмжээ нь аюул заналын цар хүрээ, шинж чанартай нийцэх хууль; системчилсэн аюулгүй байдлын хууль; улс орноо батлан хамгаалах чадвар эдийн засаг, технологийн боломжоос хамаарах хууль; цэргийн ажиллагаа, ар тал (цэрэг ба нийгэм, төр)-ын нэгдмэл байдлын хууль; улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ тэргүүлэх ач

холбогдолтой болох тухай хууль; улс орныг батлан хамгаалах нь хууль эрх зүйн хүрээнд тулгуурлах хууль зэрэг болж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Аристотель. 2018. *Политика*. М., Издательство АСТ.
2. Аристотель. 2019. *Метафизика*. М., Издательство АСТ.
3. А.Цанжид. 1996. *Улс төрийн шинжлэх ухаан*.
4. Аюулгүй Байдал, Батлан Хамгаалах Судлал: Өнөө Ба Ирээдүй. 2019. (Эрдэм Шинжилгээний Хурлын Эмхэтгэл). Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-99978-848-9-3.
5. *Батлан хамгаалах бодлого*. 2015. (эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл).
6. Ж.Энхбаяр. 2010. *Батлан Хамгаалах Эдийн Засгийн Зарим Тулгамдсан Асуудал*. Улаанбаатар.
7. Карл Маркс. n.d. *Капитал*. Критика политической экономии. (нем. Das Kapital. Kritik der politischen Ökonomie).
8. Карл Маркс, and Фридрих Энгельс. 1848. *Коммунист намын тунхаг*.
9. “Монгол Улсын үндсэн хууль.” 1992. In *Арван нэгдүгээр зүйл. 2. заалт*.
10. Платон. 1972. *Законы*. соч.: в 3 т.
11. Платон. n.d. “Государство” (или “Республика”). М., Академический проект.
12. Ц.Дашзэвэг. 2019. *Батлан Хамгаалах Бодлого, Зэвсэгт Хүчний Байгуулалт, Удирдлагын Шинэчлэл*.
13. Ц.Дашзэвэг. 2024. *Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зарим асуудалд*. Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-9919-0-3761-1.
14. Ц.Дашзэвэг. 2026. *Батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийн тулгамдсан зарим асуудал*. Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-9919-0-7439-5.
15. Ч.Баттулга, Ц.Дашзэвэг, and Б.Амартөр. 2025. *Батлан хамгаалах бодлогын хувьсал, өөрчлөлт*. Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-9919-9182-5-5.
16. Ш.Паламдорж. 2007. *Монголын шинжлэх ухаан*. 51 дүгээр боть.
17. Ш.Паламдорж. 2024. *Батлан хамгаалах судлал*. Онол, практикийн асуудлаарх эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-9919-0-2953-1.
18. Ш.Паламдорж, Ч.Баттулга, Д.Содномцог, Х.Шагдар, Ц.Дашзэвэг. 2017. *Батлан хамгаалах стратеги*. Соёмбо Принтинг ХХК, ISBN 978-99978-1-454-8.